

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Бараа материалын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хөрөнгийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинэчлэн батлах тухай		2021-02-05		ЗТ-21/02-014	
6	Цахимаар борлуулах эсэх	Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Даатгуулагчийн өмчлөл эзэмшилд байгаа бараа бүтээгдэхүүн					
	Даатгалын үндсэн эрсдэл	Байгаль, гал, сантехник, цахилгаан, хулгай, гуравдагч					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.5%-4.85%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Даатгалын зүйлийн ердийн элэгдэл, бараа материалын хэвийн хорогдол, ууршилт зэрэг тухайн эд хөрөнгө бараа материалын шинж чанараас шалтгаалан гарсан хохирол;
2. Шалган турших зорилгоор эсвэл санаатайгаар ачааллыг хэтрүүлэх болон хэвийн бус байдлыг буй болгосон аливаа тохиолдлоос үүссэн хохирол;
3. Үйлдвэрлэлийн дефектээс үүссэн хохирол;
4. Газар хөдлөлтийн улмаас даатгалын зүйлд учирсан хохирол;
5. Даатгагдсан эрсдэлээс бусад эрсдэлээр учирсан хохирол;
6. Даатгуулагч даатгалын зүйлийг хадгалах агуулахад засвар, өргөтгөл, хийцийн өөрчлөлт хийхээсээ өмнө Даатгагчид урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл аваагүй бол өөрчлөлт хийхээс үүдэн даатгалын зүйлд учирсан хохирол;
7. Даатгалын зүйлийн хадгалалтын горим, журам, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журам, норм, дүрэм эсхүл агуулахын урсгал засвар хийх шаардлагатай болон ашиглалтын хугацаа заасан зүйлүүдэд зайлшгүй хийгдэх засвар үйлчилгээний ажлыг цаг хугацаанд хийгээгүйгээс даатгалын зүйлд учирсан хохирол;
8. Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулаагүй, галын аюулгүй байдлын тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан хохирол;
9. Даатгуулагчийн өөрийн гэмт хэргийн шинж чанар, зорилготойгоор үйлдсэн үйлдлийн улмаас учруулсан аливаа хохирол;
10. Гэрээнд өөрөөр заагаагүй бол тээвэрлэлтийн үед учирсан хохирол;
11. Даатгалын эрсдэлийн улмаас даатгалын зүйлийн байршиж буй байгаль орчинд учирсан хохирол;
12. Хадгалагдаж байгаа бараа материалын зөвхөн шошго, сав баглаа боодолд учирсан хохирол;
13. Өргөн хэрэглээний барааны хувьд даатгалын үнэлгээний 3% хүртэл учирсан хохирол;
14. Даатгуулагч, түүний ажилтны сэтгэцийн эмгэг болон эрх зүйн чадамжгүй үед хийсэн аливаа үйлдлээс үүдсэн болон согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үед хийсэн үйлдлийн улмаас үүссэн болох нь тогтоогдсон аливаа хохирол;
15. Даатгуулагч даатгалын хураамжийг гэрээнд заасан нөхцлийн дагуу төлөөгүй байх үед үүссэн хохирол;
16. Хууль тогтоомжид заасан бусад.